



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 101

Баян-Овоо

2025 оны цэргийн бүртгэл явуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/675 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|--------|---|
| Ахлагч | (Засаг даргын Тамгын газрын дарга) |
| Гишүүд | (Баян-Овоо багийн Засаг дарга) |
| | (Онон багийн Засаг дарга) |
| | (Балж багийн Засаг дарга) |
| | (Агац багийн Засаг дарга) |
| | (Байгаль орчны хяналтын улсын байцаагч) |
| | (Татварын улсын байцаагч) |
| | (Улсын бүртгэгч) |
| | (Хөдөө аж ахуйн тасгийн дарга) |
| | (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн) |
| | (Архив, бичиг хэргийн ажилтан) |

2. Цэргийн бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 01 дүгээр сарын 20-ны өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

3. Цэргийн үүрэгтэн иргэдийг биечлэн болон цахимаар бүртгэж, 2024 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, цэргийн бүртгэлийн материал, мэдээ, судалгааг маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаа, хуваарийн дагуу холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ш.МОНХХУЯГ

010000002

